



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БУСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 08 сарын 01 өдөр

Дугаар A/28

Арвайхээр

Г Коронавируст халдвартын батлагдсан
тохиолдлыг эмчлэх баг томилох
тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн А/36 дугаар тушаал “Түр заавар шинэчлэн батлах тухай (КОВИД-19 Тандалт, сэргийлэлт, Хариу арга хэмжээ, Халдвартын сэргийлэлт хяналт, Лабораторийн оношилгоо, Халдвартын сэргийлэлт хийх түр заавар”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн “Коронавируст халдварт (КОВИД-19), Томуу, томуу төст өвчний эсрэг хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай 07 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвартын тархалтын нөхцөл байдалтай холбогдуулан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтний багийг нэгдүгээр, ажиллах чиг үүргийг хоёрдугаар, Антиген түргэвчилсэн тест ПСР шинжилгээний сорьцыг цуглуулах зураглалыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Халдвартын голомтод ажиллах хүний нөөцийг бэлтгэж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг сургалтын менежер (Б.Одонтuya), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрсдэлийн менежер (Д.Наранхүү), Чанарын менежер (Ж.Нарантуяа), сувилахуйн албаны дарга (Ц.Төмөрцоож), Халдвартын сэргийлэлт хяналтын албаны хяналтын ажилтан (Б.Нүрмаа), Соёл үйлчилгээний албаны дарга (Д.Баасанхүү) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Коронавируст халдвартын голомтод ажиллах эмч, ажиллагсдын илүү цагийн зардлыг журмын дагуу шийдвэрлэж ажиллахыг Санхүү эдийн засаг, хангамжийн албаны дарга Ерөнхий санхүүч (Г.Ганчөдөр)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Э.ХҮДЭРЧУЛУУН